



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/49

Ховд

Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 7.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Цамбагарав багт байрлах Тагнуулын ерөнхий газрын Ховд аймаг дахь газрын эзэмшлийн албан хэрэгцээний зориулалттай 1962 метр квадрат газрын зориулалтыг албан хэрэгцээний орон сууц, хаягийг Заны 1 дүгээр гудамжны 104 б тоот болгон өөрчилж Тагнуулын ерөнхий газрын Ховд аймаг дахь газар /9066985/-т 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрх нь баталгаажсан дээрх байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ